



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/514

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлэхэд,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Гавьяат багш Пунцагийн Нэргүй, Ардын Дуу Бүжгийн Хан Хэнтий чуулгын 40 жилийн ой, Япон улсын Токушима муж хоорондын найрамдалт харилцаанд хувь нэмрээ оруулсан Хатагтай Аратани Мидори, Хатагтай Савако Найто, Ноён Ясүши Ханамото, Модон барилдааны Дэлхийн аваргын мөнгөн медальт Цэцэгээгийн Өнөрбат, Пауэрлифтингийн мастер ангилалын Дэлхийн аваргын мөнгөн медальт Д.Баянмөнх, 4 дүгээр байр Д.Байгальмаа "Ахмадын урлагийн бага наадам 2023" арга хэмжээнд зориулан хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 2,617,400 (Хоёр сая зургаан зуун арван долоо мянган дөрвөн зуун) төгрөгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 10 дугаар сарын 12-ны
... дугаар захирамжийн хавсралт

Зардалын тооцоо

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Мөнгөн аяга	560,800	3	1,682,400
2	Талархал	60,000	6	360,000
3	Батламж	15,000	1	15,000
4	Хүндэтгэл	70,000	3	210,000
5	Зураг	350,000	1	350,000
Нийт				2,617,400